



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/212

Улаанбаатар хот

**Худалдан авах ажиллагааны 2021 оны  
төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4, 10<sup>1</sup> дугаар зүйлийн 10<sup>1.1</sup> дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.1.8 дахь заалт, 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг, 45.2.1 дэх заалт, 45.7 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Засгийн газрын 2013 оны "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 68, 2018 оны "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" 129, 2015 оны "Жагсаалт батлах тухай" 336 дугаар тогтоол, харьяа агентлаг, байгууллагаас ирүүлсэн саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хууль зүй, дотоод хэргийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-ний "Төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас худалдан авах төсөл, арга хэмжээний жагсаалт"-ыг нэгдүгээр, "Урсгал төсвийн зардлаас худалдан авах төсөл, арга хэмжээний жагсаалт"-ыг хоёрдугаар, "Өөрийн орлогоор худалдан авах төсөл, арга хэмжээний жагсаалт"-ыг гуравдугаар, "Салбарын төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар гүйцэтгүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт"-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Л.Хосбаярт даалгасугай.



DocMushaal Said. 2020 он

• 151600515

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/212 дугаар тушаалын хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛАГААНЫ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөвт өртөг /мян.төг/	2019 онд санхүүжүүлэх	Эрх шилжүүлсэн эсэх /ГЕЗ-н нэр/	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам	Худалдан авах ажиллагаанд мөрдөх хугацаа				Тайлбар
						Үнэлгээний хороо байгуулах огноо	Төндөр зарлах огноо	Гэрээ байгуулах эрх олгох огноо	Гэрээг дуусгавар болгох, дүгнэх огноо	
<b>Санхүүжилтын эх үүсвэр: Урсгал төсвөөр</b>										
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>1,270,000.0</b>	<b>100,000.0</b>							
1	Улсын бүртгэлийн хэлтсийн барилга /Хэнтий, Хэрлэн сүм/	1,270,000.0	100,000.0	Үгүй	НТШ	2021.01.08.	2021.01.08.	2021.03.31.	2021.12.20.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалт,
<b>Санхүүжилтын эх үүсвэр: Урсгал төсвөөр</b>										
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>1,001,784.0</b>	<b>1,001,784.0</b>							
1	Улсын мэдээллийн маягт хэвлэх /гэрчилгээ, үнэмлэх, лавлагаа, маягт/	578,994.00	578,994.00	Үгүй	НТШ	2021.01.08.	2021.01.08.	2021.03.31.	2021.12.20.	
2	Бичиг хэрэгсэл /бичигийн цаас, принтерийн хор, бусад/	120,000.00	120,000.00	Үгүй	НТШ	2021.01.08.	2021.01.08.	2021.03.31.	2021.12.20.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалт,
3	Багаж техник хэрэгсэл /зургийн аппарат, принтер, хурууны хээ уншигч/	150,000.00	150,000.00	Үгүй	НТШ	2021.01.08.	2021.01.08.	2021.03.31.	2021.12.20.	
4	Компьютер, тоног төхөөрөмж /Иргэний үнэмлэхийн үйлдвэрийн сэлбэг хэрэгсэл/	130,000.00	130,000.00	Үгүй	НТШ	2021.01.08.	2021.01.08.	2021.03.31.	2021.12.20.	
5	Шатахуун	22,790.00	22,790.00	Үгүй	ХА	2021.01.08.	2021.01.08.	2021.03.31.	2021.12.20.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалт